



САЙН УУ?

# Ливанаас мэндчилж байна!

Ливан улс Ойрх Дорнодод байдаг. Энд 7 сая орчим хүн амьдардаг.



Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн талаар мэдэж авахын тулд дэлхийгээр аялдаг Марго, Паоло хоёртой нэгдээрэй.

## ЛИВАНЫ ХУШ МОД

Ливан өмнө нь маш олон хуш модтой байсан. Ливаны хуш моднууд Библид 70 гаруй удаа дурдагдсан байдаг! Өнөөгийн Ливаны далбаан дээр хуш мод бий.



## ЭРГИЙН ХОТУУД

Ливаны баруун хил бүхэлдээ Газар дундын тэнгисийн эргийн дагуу байдаг. Энэ охид Ливаны нийслэл Бейрутын далайн эрэг дээр байна.

المبادئ والعهد  
الخريدة النفيسة

## АЛБАН ЁСНЫ ХЭЛ

Энэ бол Ливаны албан ёсны араб хэл дээрх Сургаал ба Гэрээ юм.



## ХОЁР ШАШИН

Ислам болон Христийн шашин нь Ливаны гол шашнууд юм. Энэ Лалын сүм Христийн сүмийн хажууд байрладаг.



## ТАББУЛЕ (TAVBOULEH)

Энэ салатыг яншуй, улаан лооль, гаа, сонгино, булгур будаа (үр тарианы төрөл) зэргээр хийдэг.

Зургийг: Кэти МакДий